



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/393

Хэрлэн сум

Орон нутгийн өмчийн газрын дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалт, Засгийн газрын 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 312 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

- 1.Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрыг шинээр байгуулж байгаатай холбогдуулан Орон нутгийн өмчийн газрын дүрмийг шинэчлэн хавсралтаар баталсугай.
- 2.Шинэчлэгдсэн дүрмийг мөрдөж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Нямдаваа)-д даалгасугай.
- 3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



ХЭНТИЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэхүү дүрмээр зохицуулна.

1.2 Орон нутгийн өмчийн газар нь /цаашид “Газар” гэнэ/ Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлогыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх нэгж мөн.

Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бодлогын бусад баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

1.3 Газар байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг Төрийн

өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

1.4 Газрын бүтэц, орон тоог аймгийн Засаг дарга баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

1.5 Газар нь зохих журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай, нягтлан бodoх бүртгэлийн тайлан тэнцэл гаргаж ажиллана.

1.6 Газрын даргыг томилох, чөлөөлөх саналыг аймгийн Засаг дарга Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргатай зөвшилцөн шийдвэрлэнэ.

1.7 Орон нутгийн өмчийн газрын ажилтныг аймгийн Засаг даргатай зөвшилцөн газрын дарга томилно.

Хоёр. Газрын бүрэн эрх

2.1 Газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн холбогдолтой хууль тогтоомж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж биелэлтэд нь хяналт тавина.

2.2 Нутгийн удирдах байгууллагаас баримталж буй бодлогын хүрээнд орон нутгийн өмчийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3 Газар нь дор дурдсан асуудлыг аймгийн Засаг даргаар уламжлуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ. Үүнд:

2.3.1 Орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх.

2.3.2 Орон нутгийн өмчийг хувьчлах бодлого, чиглэл, хувьчилж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтын санал боловсруулах.

2.3.3 Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид хамаарах эд хөрөнгийн жагсаалт, түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам боловсруулж батлуулах.

2.3.4 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг өөр өмчид шилжүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

2.3.5 Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн эд хөрөнгө, хувьцааны өөрт ногдох хувийг тодорхойлох, түүнчлэн орон нутгийн төсвийн хөрөнгө, бэлтгэл нөөц, бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийг орон нутгийн өмчид олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам боловсруулж батлуулах.

2.3.6 Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах, бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах: Хувьчлах орон нутгийн өмчийн эд хөрөнгийн жагсаалтыг батлах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн шийдвэрлэнэ.

2.3.7 Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, шинээр байгуулах замаар орон нутгийн өмчийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх санал боловсруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

2.3.8 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

2.3.9 Орон нутгийн өмчийн байгууллагуудын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай санал боловсруулж шийдвэрлүүлэх.

2.3.10 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

2.3.11 Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох, санал боловсруулж шийдвэрлүүлэх.

2.3.12 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг зохион байгуулж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх.

2.4 Орон нутгийн өмчийг хувьчилсны орлого болон түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

2.5 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан ажлын дүнг тайлagna.

2.6 Орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эд хөрөнгийн анхан шатны бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулж хяналт тавих.

2.7 Орон нутгийн өмчийн бүртгэл, судалгааг батлагдсан маягт журмын дагуу хагас, бүтэн жилээр гаргаж Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж холбогдох арга хэмжээг зохион байгуулах.

2.8 Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд компанийн сайн засаглал, орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх.

2.9 Орон нутгийн өмчийг хуульд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай ашиглуулах, эзэмшилт ашиглалтгүй байгаа өмчийг хуулийн этгээдэд эзэмшүүлэх, өмчийг зүй бусаар ашиглах, завших, элдэв хэлбэрээр үрэгдүүлэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авах, уг ажилд эрх бүхий мэргэжлийн хэлтэс, албадыг татан оруулж баталгаа, дүгнэлт гаргуулах.

2.10 Орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах.

2.11 Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хулээн авч тулган баталгаажуулах, нэгтгэх.

Гурав: Газрын ажлын зохион байгуулалт

- 3.1 Газар нь ажлаа Засаг даргын өмнө бүрэн хариуцна.
 - 3.2 Газар нь өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт, зардлын тооцоог санхүүгийн жил эхлэхээс өмнө гаргаж дараа жилийн орон нутгийн төсөвт тусгувлан шийдвэрлүүлнэ.
 - 3.3 Газрын үйл ажиллагааны тайланг албаны дарга аймгийн Засаг даргатай байгуулсан үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтийн хамт жилээр гарган дүгнүүлж ажиллана.
 - 3.4 Ажлын эрх ашигт нийцүүлэн ажлын байр, хөдөлмөрийн багаж төхөөрөмж, унааны зардал бусад хангамжийн асуудлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.
- Дөрөв: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
 болон Орон нутгийн өмчийн газар хоорондын харилцаа**
- 4.1 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Орон нутгийн өмчийн газрыг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд энэхүү журмын 1.3, 2.3.5-д зааснаас гадна дараах эрх үүрэгтэй байна. Үүнд:
 - а/ Орон нутагт байгаа төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих.
 - б/ Өмчийн асуудлаар хамтарч ажиллах, харилцан мэдээлэл солилцох, орон нутгийн өмчийн талаарх шаардлагатай мэдээллийг гаргуулан авах.